



III/2022


Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13



## Нас гүйцсэн эр хонины үнэ Улаанбаатар хотод хамгийн их буюу 300.0 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 3 дугаар сард атны үнэ 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 29.7 мянган төгрөгөөр өсөж, соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 3.9 мянган төгрөг, хязаалан гуных 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 2.6 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Харин эр хонины үнэ 218.2 мянган төгрөг болж, өмнөх сараас 4.3 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 156.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.9 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), 2022 оны 3 дугаар сард, мянган төгрөгөөр




Эр хонины үнэ 2022 оны 3 дугаар сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 300.0 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна. Хөвсгөл аймагт хамгийн бага буюу 172.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.1 мянган төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 3 дугаар сард, мянган төгрөг




Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 3 дугаар сард боодолтой өвсний (20 кг) үнэ Говь-Алтай аймагт хамгийн их буюу 12.6 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 2.5 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. БООДОЛТОЙ ӨВСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, 2022 оны 3 дугаар сард



Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 3 дугаар сард 6.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 700 төгрөгөөр буурсан байна. Харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 133.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 29.0 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 3 дугаар сард, төгрөг



Хивэгний (25 кг) үнэ 2022 оны 3 дугаар сард Хэнтий аймагт хамгийн их буюу 25.0 мянган төгрөг, Дархан-Уул аймагт хамгийн бага буюу 10.0 мянган төгрөг байна.

**Тооцох аргачлал:**

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



**Эх үүсвэр:**

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

**Мэдээлэл авах холбоос**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ гархаах хуваарь:**

2022 оны 5 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга  
А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн газрын  
Үнийн статистикийн хэлтсийн гэрээт  
ажилтан Б.Оргил  
Утас : (976-51)-261563

